

## НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ, ШҮҮМЖ

**ХЯТАДЫН ХЭТ ИХ ГҮРНИЙ  
ХИЙ МӨРӨӨСӨЛ  
(Шүүмж)**

Ш. Бхушаны бичсэн «Хятадын хэт их гүрний хий мөрөөсөл» гэдэг номыг Дели хотын ардын секторын дэвшилт хэвлэлийн газраас 1976 оны 9-р сард хэвлэн гаргажээ. Уг ном Ази дахь объектууд (1), жанжлах санаархал (V), цөмийн дайн (XXX), хөрш орнуудын талаархи бодлого (XXII) гэх мэт 32 бүлэгтэй, оршил, нэрсийн хэлхээстэй 216 хуудас ном юм.\*

Хятад улс эвсэлд үл нэгдэгч болон социалист орнуудад дайсагнаж байсан, одоо ч дайсагнасаар байгаа гүрнүүдтэй гүн сүлбэлдэж Хятадын одоогийн эрх баригчид, маоистууд анхнаасаа эхлээд Америкийн цэргийн баазыг Ази болон газар сайгүй байлгах дуртай, АНУ, Японтой хамтарч социалист орнуудын эсрэг хандсан «Номхон далайн гурвалжин холбоо» гэгчийг байгуулах эрмэлзлэлтэй, Европт бас АНУ-ын цэргийг байлгаж НАТО-г чангалж улмаар Зүүн Европын орнуудын эсрэг «хоёрдугаар Фронт» болж байхыг мөрөөдөж байна гэсэн бодит судалгаандаа үндэслэн маоист Хятад нь олон улсын намжмал байдлын эсрэг ажиллаж байна гэж зохиогч дүгнэхэд хүрсэн нь уг номын удиртгалаас эхлэн харагдаж байна.

Шаши Бхушан номоо бараг 3 жилийн өмнө бичсэн боловч ер хэдхэн сарын өмнө бичсэн гэж болохуйц байгаа нь уг номд дурдсан олон талын баялаг баримт, дүгнэлт Хятад дахь саяхны болон одоогийн үйл явдлуудыг санагдуулж байгаатай холбоотой юм. Энд Хятад-Вьетнамын харилцааны онцлог, Хятад-Японы найрамдлын гэрээний тухай мөн Монголтой холбогдсон зэрэг олон жишээг нь иш татаж болно. Энэтхэгийн төрийн болон олон нийтийн нэрт зүтгэлтэн, парламентын гишүүн агсан Ш. Бхушан Хятадыг сайн мэддэгийн хувьд 1972 оноос эхлэн Хятадын талаар олон тооны ном, өгүүлэл бичсэний дотор «Хятад фашизм руу явж байна» гэдэг ном нь 1975 онд хэвлэгджээ.

Хэрэв урд нь бичсэн эдгээр бүтээлгүйсэн бол зохиогчид «Маогийн дараахь маоизм» гэдэг тусгай бүлэгтэй, Хятадын гадаад харилцаа, түүний чиг шугамыг энэ мэт нягтлан базаж багтаасан номыг Маог нас барснаас хойш хэдхэн долоо хоногийн дотор хэвлэн гаргахад хялбаргүй байсан нь мэдээж. Гэвч зохиогч Хятадын орчин үеийн гадаад бодлогод оновчтой дүн шинжилгээ хийснээр барахгүй маоизмын мөн чанартай холбогдсон онолын зарим асуудлыг хөндөж тодорхойлохыг оролдсон онцлогтой ажээ. Тухайлбал, маоизмын ул суурь нь хэт үндэсний үзэл, ганц хүнийг тахин шүтэх явдал, милитаризм гурав бөгөөд тэдгээр нь ганц хүний удирдлагагүйгээр байж болохгүй агаад, маоизм дээр үндэслэсэн хамтын удирдлагын замаар бүтэхгүй зүйл юм. Энэ нь маоизмын дотоод зөрчил бөгөөд түүний улмаас маоизм нь ямар ч ирээдүйгүй (11-12-р талууд), маоизм нь ажилчин ангийн үзэл суртал биш (193-р тал) гэж дүгнэжээ.

\* Shashi Bhushan M. P. China The Myth of a Super Power, Progressive peoples sector publications (P) Ltd. New Delhi. 1976. p. 216.

Ш. Бхушан энэ номдоо маоизмын үзэл суртлын мөн чанар нь их гүрний дээрэнгүй үзэл мөнийг олон талаас нь нотолж бээжингийн удирдлагын зөвлөлтийн эсрэг үзэл, «гуравдахь ертөнцөд» явуулж буй жанжлах бодлогын үнэн нүүр царай, хятад дахь үндэстний цөөнхийг хятадчилж буй явдал, хөрш орнууд руу өнгөлзөх бодлого явуулж байгаа зэргийг тодорхой харуулжээ. Хятадын эрх баригчид энэ бодлогоо хэрэгжүүлэхийн тулд империализмын харгис хүчинтэй улам бүр ойртон сүлбэлдэж байгаа талаар зохиогч баялаг баримт сэлтэд тулгуурлан бодит байр сууринаас хандаж бичсэн байна. «Өөрийн шинж чанараараа маоизм шинжлэх ухааны социализмын сургаалтай хавьтах зүйлгүй юм...Маоизм бол үндсэрхэх үзэл бүхий жижиг хөрөнгөтний үзэл» гэж зохиогч маоизмын үзэл санааг тодорхойлжээ. (191-р тал).

Хятадын жижиг хөрөнгөтний бие төлөөлөгч Мао Цзэдун засгийн эрхэнд гарч, ХКН-ын удирдлагад байр сууриа бэхжүүлсний дараахь жилүүдэд ч гэсэн жижиг хөрөнгөтний үзэл бодлогоосоо ангижирч чадаагүйгээр барахгүй Сун Ят-сэний ардчилсан уламжлалаас хүртэл ухарч улмаар Маогийн жижиг хөрөнгөтний үзэл бодол нам, төрийн албан ёсны бодлого болж хувирсан тухай зохиогч тэмдэглээд «Бээжингийн удирдлагын дотоод гадаад бодлогод шинжлэх ухааны социализмын үндсийг тавигч Маркс, Энгельс, Ленин нарын бичиж байсан социализмтай зүйрлэх юм алга» гэж дүгнэжээ. (121-р тал). Үнэхээр Маогийн бүлгийхэн Хятадад социализм байгуулах зүй тогтоолт үндсэн зарчмаас ухарч хувьсгалч номчирхлоор халхавчлан олон улсын коммунист ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд жанжлах байр суурийг олж авах гэж махран зүтгэж байна. Бээжин олон улсын империализм, хамгийн харгис хүчинтэй ойртох замаар Зөвлөлтийн эсрэг «өргөн фронт» гэгчийг байгуулахаар санаархаж байна гэж Хятадын маоист удирдлагын олон улсын тавцан дээр явуулж байгаа адал балмад үйл ажиллагааг Бхушан номдоо илчлэн харуулжээ.

Маогийн бүлэг Хятадад «их үсрэлт», «Пролетарийн соёлын их хувьсгал» гэх мэтийн эдийн засаг, улс төрийн адал балмад хэрэг явдлыг зохион байгуулж, «зөвлөлтийн аюул» гэдэг гүтгэлгийн дор улс орныг цэрэг дайны бэлтгэлд татан оруулж байгаа нь үнэн хэрэгтээ цэрэг зэвсгийн талаар хүчирхэг Хятад гүрнийг босгож дэлхий дахинд жанжлах бодлогоо явуулах боломж олж авах гэсэн санаархал гэдгийг зохиогч номдоо жишээ баримттайгаар дэлгэрэнгүй бичжээ.

Хятад цөмийн зэвсгийн үйлдвэрлэлтийг боловсронгуй болгохын хойноос улайран хөөцөлдөж улсынхаа төсвийн 40 гаруй хувийг цэрэг дайны зардалд зориулж байгаагаас гадна хятадын аж үйлдвэр, хөдөө аж ахуйн зонхилох салбарууд цэрэг дайны зориулалттай ажиллаж байна. Ийнхүү Бээжингийн маоист удирдлага их гүрний жанжлах бодлогоо хэрэгжүүлэх гол хүчин зүйлээ улс орныг нэлэнхүйд нь цэрэгжүүлэх явдал гэж үзэх байна. Энэ талаар Ш. Бхушан номдоо, Хятад өнөөдөр 4 сая гаруй цэрэгтэй байнгын армитайгаас гадна бүх нийтийг цэрэгжүүлэх бодлогыг идэвхтэй явуулж үйлдвэр, хөдөө аж ахуй, албан байгууллагад Маогийн цэрэг-хүнд суртлын алпарат ноёлж байгаа тухай дурдаад Өвөр Монгол, Төвд, Синьцзян зэрэг автономит районуудын ард түмнийг «Зөвлөлтийн аюул», «Гаднын аюул» гэдгээр айлган сүрдүүлж тэдний хүч хөдөлмөр, байгалийн баялгийг дайны бэлтгэлд шавхан дайчилж буй тухай өгүүлжээ.

Бээжингийн удирдлага хятадыг «хөгжиж байгаа социалист орон» гэж тунхаглаад «гурав дахь ертөнцөд» хамаарагдана гэж байна. Хятад «гурав дахь ертөнцийн» шинэ тулгар хөгжиж байгаа орнуудын «өмөг түшиг» нь юм гэж тэдэнд итгүүлэхийг оролдож «гурав дахь ертөнцийн» орнуудыг өөрийн их гүрний жанжлах бодлогоо хэрэгжүүлэхэд ашиглах гэж санаар-

хаж байна. Бээжингийн гадаад бодлогын хөрш зэргэлдээ орнуудынхаа дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох, газар нутагт нь өнгөлзөх, түрэмгийлэн эзлэх чиг шугам нь Хятадын их гүрний жанжлах санаархлын салшгүй хэсэг нь болж байгааг зохиогч тодорхой жишээтэйгээр бичсэн байна. Маогийн бүлгийнхэн 1955—1956 онд Хятад-Бирмийн хил дээр, 1959—1962, 1967 онд Хятад Энэтхэгийн хил дээр тус тус зэвсэгт мөргөлдөөн зохион явуулж ихээхэн газар нутгийг эзэлж авсан. Мөн 1974 оны 1-р сард хятадын маоист удирдлага Өмнөд Хятадын тэнгист оршдог БНСВУ-ын эзэмшлийн Параселлын арлуудыг цэрэг зэвсгийн хүчээр байлдан эзэлсэн байна. Мөн тэнд байдаг Спратли аралд тэд өнөөдөр өнгөлзөж байна.

«Орчин үеийн хятадын товч түүх» гэдэг Бээжинд хэвлэгдсэн дунд сургуулийн сурагчдын сурах бичигт Бирм, Тайланд, Балба, Энэтхэгийн Ассам муж, Андаманы арлуудыг хятадын нутагт хамааруулан зурснаас гадна «БНХАУ-ын Атлас» гэдэг хэвлэлд мөн иймэрхүү байдлаар Бирмийн нутгийн нилээд хэсгийг хятадад оруулан зурсан байна 36-р тал/.

Газрын зураг зүйн түрэмгийлэл явуулж сүүлийн үед хятадад хэвлэн гаргасан газрын зурагт Зөвлөлтийн Владивосток, Хабаровск, Байгал нуураас баруун тийш газар нутаг цөм «хятадын нутагт» багтаж байгаа бөгөөд мөн Памир, Амарын сав газарыг ч «хянаж үзэх ёстой» газар нутаг гэж Бээжингийн удирдлага үзэж байгаа юм гэж Бхушан бичсэн байна.

«Бээжингийн удирдлагаас бусад оронтой найрсаг харилцаатай байх» гэдгээр тэдгээр орны дотоод хэрэгт оролцож албан ёсны засгийн газрыг хүртэл элдэв арга мэхээр түлхэн унагаахад бэлэн байна.» (38-р тал) гэж Бээжингийн маоист бүлгээс бусдын дотоод хэрэгт бүдүүлгээр ороцлож байгааг Шри Ланка, Пакистан зэрэг орнууд дахь саяхны хэрэг явдлуудын жишээ баримтаар илчилжээ.

Бээжингийн маоист удирдлага өөрсдийгөө «үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өмөг түшиг» гэж аман дээрээ номлох боловч ажил хэрэгтээ эрх чөлөөнийхөө төлөө тэмцэж байгаа ард түмний эсрэг империализм, колоничлол, харгис хүчнийхэнтэй хуйвалдаж байдгийг зохиогч Бангладешид болсон хэрэг явдлаас иш татаж «Бээжингийн удирдлага Бангладешийн ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг багалзуурдах бодлого явуулж байсан юм. Тэд тэр үеийн Пакистаны цэргийн харгис дэглэмийн толгойлогч генерал Якья Хан-д зүйл бүрийн тусламж дэмжлэг үзүүлж байв. Бангладешийн ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дарахаар Бенгалийн буланд АНУ-ын 7-р флотыг оруулж ирэхэд Хятад Пакистаны тэр үеийн удирдлага ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм» гэж Бхушан бичжээ. (129-р тал).

Бээжингийн удирдлагаас Энэтхэгийн салбар тивд их гүрний жанжлах бодлогоо явуулахад тэдэнд ихээхэн бэрхшээл учруулах орон бол эвсэлд үл нэгдэх бодлого тууштай явуулж байгаа энэтхэг улс гэж тэд үзэж байна. Тийм ч учраас Энэтхэгийн эсрэг Бээжин элдэв өдөөн хатгасан түрэмгий үйл ажиллагааг удаа дараа явуулж ирснийг зохиогч тодорхой баримтаар нотолжээ.

Бээжингийн эрх баригч бүлэг Энэтхэгийн салбар тивийн орнууд болон ЗХУ, социалист нөхөрлөлийн бусад орнуудын хоорондох найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг задлан бутаргах, өмнөд Азид өөрийн их гүрний жанжлах бодлогоо чөлөөтэй явуулах боломж олж авахыг зүйл бүрээр оролдохдоо Зөвлөлт Энэтхэгийн хоорондын найрамдалт харилцаа, үр бүтээлт хамтын ажиллагааг элдвээр муучлан гүтгэж байгааг Ш. Бхушан тодорхой бичжээ. Эрт дээр үеэс Зүүн Өмнөд Азийн орнуудаар тархан суусан хятад иргэдийг Бээжингийн удирдлага өөрийн их гүрний жанжлах бод-

логодоо ашиглаж байна. Ш. Бхушаны номд бичсэнээр «Өнөөдөр Зүүн Өмнөд Азийн орнуудад барагцаалбал 20 сая орчим хятад иргэд оршин сууж байна. Энэ нь Зүүн өмнөд Азийн нийт хүн амын 6 орчим хувь нь болж байгаа ажээ. «Энэ районы эдийн засагт хятад иргэдийн эзлэх хувийн жин улам бүр өсч одоо Зүүн Өмнөд Азийн дотоод худалдааны 15 орчим хувь нь хятад иргэдийн гарт байна» гэж Ш. Бхушан бичжээ.

Зохиогч номдоо хилийн чанадад оршин суугаа хятад иргэдийн талаар явуулж байгаа Бээжингийн бодлогыг эдийн засгийн ашиг хонжоо олох, суугаа орныхоо засгийн газарт улс төр, эдийн засгийн даралт шахалт үзүүлэх үндсэн хоёр зорилгод чиглүүлэн ашиглаж байгаа тухай тодорхой жишээгээр иш татан бичсэн байна.

Бээжингийн маоист удирдлага хятадын автономит районд оршин суугаа хятад бус үндэстнүүдийн хувьд хан үндэсний үндэсний дээрэнгүй бодлогоо явуулж тэдний түүхийг гуйвуулж, соёл урлаг, шашин шүтлэгийн эрх чөлөөг хавчин гадуурхаж «хуучны үлдэгдэлтэй» тэмцэх нэрээр тэр бүгдийг устгаж хятадчилах бодлого явуулан, тэдгээр орны ард түмний хүч хөдөлмөр, байгалийн баялгийг өөрийн их гүрний жанжлах бодлогынхоо зорилгод ашиглаж, автономит районы ард түмнийг «Зөвлөлтийн аюул», «гаднын аюул» гэдгээр айлган сүрдүүлж байгаа талаар зохиогч дэлгэрэнгүй бичсэн байна.

«Монгол үндэстнийг хятадчилах бодлого явуулсны улмаас уугуул нутагтаа оршин суугаа монголчуудын тоо «соёлын хувьсгалаас» хойш эрс буурав. Харин Өвөр Монгол, Төвдөд нүүлгэн ирүүлсэн хятад иргэдийн тоо олшров, «Соёлын хувьсгалын» өмнө Өвөр Монголын газар нутаг 1.4 сая ам/км байсан бол энэ орны зарим аймгийг өөр мужид нийлүүлснээс 1969 онд 600000 ам/км болж багасчээ. «Соёлын хувьсгалын» өмнө Өвөр Монгол дахь монголчууд 1,1 сая байсан бол «соёлын хувьсгалын» үеэр тэн хагасыг нь өөр мужид шилжүүлэн суулгасан байна.

Бээжингийн удирдлага монголчуудын төрөлт, гэрлэлтэнд хяналт тавьж эрэгтэй нь 30, эмэгтэй нь 25 нас хүрэхээс нааш гэрлэж болохгүй, гэрлэснээс хойш 3 жил болж байж хүүхэд төрүүлэх, нэг гэр бүл 2-оос дээш хүүхэд гаргаж болохгүй гэсэн хууль гаргасан байна» гэж зохиогч бичжээ. (55-р тал).

Цэрэгт татагдсан монголчуудыг буцаж ирэх боломжгүй хятадын алслагдсан өмнөд мужид илгээж, монгол охидуудыг хятад хүнтэй гэрлүүлж, гарсан хүүхдийг нь хятад үндэстэн гэж бүртгэн авдаг.

Хот суурин газар тогтмол цалинтай ажил олж хийх явдал монгол залуучуудад аз жавшааны хэрэг болдог байна. Гэтэл тэднийг ажилд зөвхөн дадлагажигчаар авдаг. Дадлагажигч хугацаа нь хятад хүмүүст 2-3 жилээс хэтрэхгүй байхад монголчуудад 7-8 жил байдаг байна.

Хэрэв монгол ажилчин 7—8 жилд бүх үзүүлэлтээрээ «сайн хятад хүн» (бид хаалтанд авав) болж чадвал түүний цалинг 10 юанаар нэмдэг байна. Бүх үзүүлэлтээрээ «сайн хятад хүн» болно гэдэг нь Маогийн сургаалыг идэвхтэй судалж бүрэн эзэмших, хятадаар чөлөөтэй ярьдаг болох, Монгол үндэсний зан уламжлалаасаа татгалзахыг хэлж байна.

Монгол ажилчин 35 юаний цалинд хүрэхийн тулд наад зах нь үйлдвэрт 10 жил ажиллах шаардлагатай байдаг байна. Монгол ажилчид үйлдвэрт 12 цаг ажиллаад 8 цагийн ажлын хөлс авна. Улс төрийн боловсрол дээшлүүлэхээр хятад ажилчид ажлынхаа дараа 2 цаг улс төрийн хичээл хийдэг бол монгол хүн 4 цаг хичээллэдэг байна. Өвөр монголчуудыг өөрийн нутаг дэвсгэрийн заагаас гадагш оршин сууж байгаа буюу гадаадад бай-

гаа монгол үндэстэн нартай харилцаа холбоотой байхыг хориглодгоос гадна нутаг усаа сольж нүүдэллэхийг хоригложээ.

«Бээжингийн их гүрний үндсэрхэх дээрэнгүй үзэлд нэрвэгдсэн хятад дахь үндэсний цөөнхийн соёл урлаг, үндэсний зан заншил устгагдаж шашин шүтлэгийн эрх чөлөө хаалттай байна» гэж Ш. Бхушан тэмдэглээд Бээжингийн удирдлага Төвдийг «тайван замаар чөлөөлөх» нэрээр эзэлж авснаас хойш Төвд орны ард түмний аж байдал эрс доройтсоныг тодорхой баримтаар харуулжээ.

Одоогийн Төвдийн «Автономит район» гэгдэж байгаа нутагт 1950 оны өмнөх Төвдийн газар нутаг, хүн амын зөвхөн тал хувь нь оржээ. Төвдийн нутгийн ихээхэн хэсгийг Цинхай, Сычуань, Юаньнань, Гансу зэрэг хятад үндэстэн оршин суудаг мужуудад нэгтгэжээ. Мөн Хятад Төвдийн хил дагуу оршин суугаа олон тооны төвд үндэстнийг «Автономит районы» бүрэлдэхүүнд оруулаагүй байна. Тэр ч байтугай тэднийг хан үндэстэн гэж албан ёсоор нэрлэдэг болжээ» (171-р тал).

Бээжингийн удирдлага Төвдийг стратегийн түшиц газар болгон хувиргаж тэд хятадын сая орчим цэрэгтэй арми, өдий төдий цэргийн бааз байгуулж байна. Төвд өнөөдөр хятадын цэргийн 11 чухал районы дөрөвдүгээрт зүй ёсоор орж байна гэж Бхушан бичжээ. (171-р тал).

«Өнөөдөр БНХАУ-ын гадаад бодлого олон улсын империализмыг эсэргүүцэх шинж чанараа бүрмөсөн алдаад байна. Тийм учраас Бээжингийн удирдлагын империализм, фашизм, колоницлол, шинэ колоницлолын эсрэг тэмцэлд бүх хувьсгалт хүчний эв нэгдлийг бэхжүүлнэ гэдэг нь зөвхөн худал хоосон яриа юм» гэж зохиогч тэмдэглэсэн байна (182-р тал).

«Зөвлөлтийн социал-империализм» бол хятадын 1-р зэргийн дайсан гэж хятадын удирдлага үзэх болсон тухай Бхушан тодорхой шүүмжлэн бичжээ.

Бээжингийн удирдлага «социал-империализм», «Хэт их гүрний жанжлалын» эсрэг явуулах тэмцэл гэдэг нэрийн доор Азид гадаадын түрэмгий цэргийн бааз, эвсэл холбоог хэвээр байлгах, Япон-Америкийн «Аюулгүйн гэрээ» гэгчийг дэмжиж, хятад-Японы «энх тайван, найрамдлын тухай гэрээнд» «Жанжлалын эсрэг тэмцэх» гэдэг зөвлөлтийн эсрэг гүтгэлгийг шургуулахыг махран хөөцөлдөж, Умарт Атландын цэргийн түрэмгий эвслийг бэхжүүлэн түүнийг Варшавын гэрээний эсрэг тавих, намжмал байдлын үйл явцыг улайран эсэргүүцэж, хүйтэн дайны бодлогод эргэж оруулахыг санаархаж байна. ХКН-ын X их хурал дээр Чжоу Эн-лай хэлсэн үгэндээ: «Намжмал байдал гэдэг нь түр зуурын онцгой хэрэг явдал юм. Цаашид эмх замбараагүй явдал үргэлжлэнэ» гэж хэлсэн тухай зохиогч бичжээ.

Зохиогч номдоо Монголын ард түмнээс ардын хувьсгалын жилүүдэд улс төр, эдийн засгийнхаа салбарт олсон ололт амжилтыг үнэн зөвөөр тусгаснаас гадна бээжингийн удирдлагаас БНМАУ-ын эсрэг явуулж байгаа их гүрний дээрэнгүй үзэл, БНМАУ-ыг ЗХУ болон социалист нөхөрлөлийн хань нөхдөөс нь салгах, БНМАУ-ын дотоод хэрэгт орж, газар нутагт нь өнгөлзсөн өдөөн хатгасан балмад бодлогоо явуулж байгаа тухай зохиогч тодорхой бичжээ.

Бээжингийн удирдлагаас удаа дараа гаргаж байсан газрын зурагтаа Хятадын хөрш зэргэлдээ бусад улсуудын нэгэн адил БНМАУ-ыг хятадын нутагт оруулан зурж хятад-монголын хилийн орчимд хилийн будлиан гаргаж өдөөн хатгалга хийж, БНМАУ-д эдийн засгийн даралт шахалт үзүүлж Монголын нутгаар дайран гарч байгаа олон улсын төмөр замын

тээврийг ачаа бараагаар зориуд боогдуулж байв. Эдийн засгийн тусламжийн шугамаар барьж байгуулсан барилга байгууламж нь чанар чансаа муутай, тоног төхөөрөмж нь хуучирсан, удаан хугацааны эдэлгээ даахгүй болсон байдаг. Тухайлбал, Улаанбаатар хотын ойролцоо барьсан шилний үйлдвэрт хуучин тоног төхөөрөмжийг будаж тавьсан байлаа» гэж зохиогч бичсэн байна (59-р тал).

«БНМАУ-д эрт дээр үеэс эхлэн аж төрөн амьдарч ирсэн хятад иргэдийг Бээжингийнхэн БНМАУ-ын эсрэг явуулж байгаа балмад үйл ажиллагаандаа татан оруулж байна. Тэдэнд хандаж «Монголын ревизионистуудтай тэмцэхэд бэлэн бай! Мао даргын заалтыг өргөн дэлгэрүүл» гэх зэргээр уриалдаг байсан тухай бичжээ (64-р тал).

Мөн Улаанбаатарт байгаа Хятадын элчин сайдын яам «соёлын хувьсгалын» жилүүдэд БНМАУ-ын эсрэг цуглаан жагсаал зохион байгуулах, эмх замбараагүй байдал бий болгох, Маогийн үзэл суртлыг суугаа орондоо дэлгэрүүлэхэд чиглэсэн ажил зохион байгуулж байв. Улаанбаатарт байсан хятад эмнэлгийн хэрэгцээний «эмийн зүйл» гэдэг нэрийн дор Маогийн зохиолын эмхтгэл 4500 ширхэг, Маогийн ишлэлийн эмхтгэл 500 гаруй ширхэг, элдэв гүтгэлгийн материал өдий төдий мянгыг Монголд тарааж байлаа гэж Бхушан бичсэн байна.

Бхушаны номд Бээжингийн маоист удирдлагаас зөвхөн Азид төдийгүй Африк, Латин Америкийн орнуудад явуулж буй их гүрний жанжлах санаархал, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эсрэг тэдний задлан бутаргагч хоёр нүүртэй бодлогыг хурц тодоор илчилсэн судалгааны чанартай баялаг баримт материал оруулсан нь уг номын нэг ололт болно. зохиогч орчин үеийн хятадын нийгмийн бүтэц болон маоизмын талаар онолын зарим асуудлыг хөндөж «Хятадын их удирдагч онгон шүтээн, хэт үндэсний үзлийнхээ зууш болох тавилантай байжээ. Маогийн дараа, түүний нас нөгцсөнөөр буй болсон хоосон зайг маоизм дүүргэж чадахгүй юм. Маоистууд милитаризм ба зэр зэвсгийн хуримтлал л маоизмыг амьд байлгана гэж санаж байна. Гэтэл шинжлэх ухааны социализмд харшлагч маоизм яваандаа балран унах тавилантайг тэд умартаж байна» (11-12) гэсэн дүгнэлт хийжээ.

Энэтхэгийн олон нийтийн зүтгэлтэн Бхушаны энэ ном өнөөгийн хятадын их гүрний жанжлах дээрэнгүй үзэл, Маогийн «улаан номоор» уг үндсээ болгосон Бээжингийн эрх баригчдын гадаад бодлогын мөн чанарыг дэлхийн олон нийтэд үнэн бодитойгоор илчлэн харуулсан «цагаан ном» гэж болох бүтээл болжээ.

**Д. Пүрэв.**